



НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2024 болон 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

(Канад доллараар илэрхийлсэн)

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан
(Канад доллар)

	Тодруулга	2025.12.31	2024.12.31
Хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		\$ 4,659,397	\$ 7,298,399
Дансны авлага		319,428	14,910
Урьдчилж төлсөн зардал		215,979	69,988
Эргэлтийн хөрөнгийн дүн		5,194,804	7,383,297
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	5	46,925,365	53,109,742
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	6	3,781,684	2,468,070
Үндсэн хөрөнгө		78,458	39,104
Хөрөнгө ашиглах эрх		86,382	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		50,871,889	55,616,916
Нийт хөрөнгийн дүн		\$ 56,066,693	\$ 63,000,213
Өр төлбөр			
Арилжаа ба бусад өглөг		\$ 1,444,437	\$ 782,851
Түрээсийн төлбөр		24,875	-
Богино хугацаат өр төлбөр		1,469,312	782,851
Түрээсийн төлбөр		63,958	-
Урт хугацаат өр төлбөр		63,958	-
Нийт өр төлбөрийн дүн		1,533,270	782,851
Эздийн өмч			
Хувьцаат капитал	9	\$ 170,720,582	\$ 165,589,487
Нэмж төлөгдсөн капитал	9	30,487,498	30,656,061
Бусад дэлгэрэнгүй орлогын хуримтлагдсан дүн		(1,739,047)	2,725,582
Алдагдал		(144,935,610)	(136,753,768)
Эздийн өмчийн дүн		54,533,423	62,217,362
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		\$ 56,066,693	\$ 63,000,213

Гэрээгээр хүлээсэн үүрэг (Тодруулга 7)

Тайлант хугацаанаас хойш өрнөсөн үйл явдлууд (Тодруулга 15)

Дагалдах тодруулгууд нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)-ийг төлөөлж баталсан:

Гарын үсэг зурсан “Петер К.Акерли”

ТУЗ-ийн гишүүн

Гарын үсэг зурсан “Кеннет В.МакДоналд”

ТУЗ-ийн гишүүн

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Алдагдал болон Дэлгэрэнгүй Алдагдал (Орлого)-ын Нэгтгэсэн Тайлан

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

	Тодруулга	12.31-нд дуусгавар болсон жилийн хугацаа	2025	2024
Үйл ажиллагааны зардал				
Хайгуул, үнэлгээний зардал	10	\$	2,448,232	\$ 1,852,642
Ерөнхий ба удирдлагын зардал	11		3,997,960	5,043,058
Үйл ажиллагаанаас учирсан алдагдал			6,446,192	6,895,700
Хараат компанийн хөрөнгө оруулалтын алдагдал	5		1,917,471	3,245,109
Санхүүгийн орлого			(188,265)	(164,261)
Хүүгийн зардал			4,716	427
Гадаад валютын ханшийн зөрүүнээс гарсан гарз (ашиг)			1,728	(474,491)
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын эзэмшлийн хувь бууралттай холбоотой ашиг	5		-	(1,256,598)
Цэвэр алдагдал		\$	8,181,842	\$ 8,245,886
Бусад дэлгэрэнгүй алдагдал (ашиг)				
Охин компанийн хөрвүүлгээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү			197,723	(166,428)
Хараат компанийн хөрвүүлгээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү	5		4,266,906	(3,849,522)
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын хувь буурсантай холбоотой гадаад валютын ханшийн зөрүү	5		-	440,770
Бусад дэлгэрэнгүй алдагдал (ашиг)			4,464,629	(3,575,180)
Нийт дэлгэрэнгүй алдагдал		\$	12,646,471	\$ 4,670,706
Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдал		\$	0.13	\$ 0.14
Гаргасан болон эргэлтэд буй хувьцааны жигнэсэн дундаж тоо ⁽¹⁾			60,983,853	58,075,921

Дагалдах тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

⁽¹⁾ Компани нь 2025 оны 9 сард энгийн хувьцааг нэгтгэсэн бөгөөд энгийн хувьцааны тоог өмнөх хугацаанд буцаан тусган тооцсон. Дэлгэрэнгүй мэдээлэлтэй Тайлбар 1-ээс танилцана уу.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан
(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

	Тодруулга	Хувьцааны тоо ширхэг ⁽¹⁾	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй ашиг (алдагдал)	Алдагдал	Нийт эздийн өмч
2025.01.01-ний байдлаар		60,356,137	\$ 165,589,487	\$ 30,656,061	\$ 2,725,582	\$ (136,753,768)	\$ 62,217,362
Тайлант үеийн нийт алдагдал							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(8,181,842)	(8,181,842)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	(4,464,629)	-	(4,464,629)
Хэрэгжүүлсэн опцион	9	1,378,175	4,913,195	(1,538,971)	-	-	3,374,224
ИОХЭ-ийн дагуу гаргасан энгийн хувьцаа	9	135,015	217,900	(217,900)	-	-	-
Хувьцааны нэгтгэлтэй холбоотой гаргасан энгийн хувьцаанд суурилсан урамшуулал	1	4,889	-	-	-	-	-
Хувьцаанд суурилсан урамшуулал	9	-	-	1,588,308	-	-	1,588,308
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл, гүйлгээ		1,518,079	5,131,095	(168,563)	-	-	4,962,532
2025.12.31-ний байдлаар		61,874,216	\$ 170,720,582	\$ 30,487,498	\$ (1,739,047)	\$ (144,935,610)	\$ 54,533,423
2024.01.01-ний байдлаар		57,481,312	\$ 158,086,286	\$ 30,147,989	\$ (849,598)	\$ (128,507,882)	\$ 58,876,795
Тайлант үеийн нийт алдагдал							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(8,245,886)	(8,245,886)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	3,575,180	-	3,575,180
Хэрэгжүүлсэн опцион	9	550,851	1,182,755	(366,005)	-	-	816,750
Хэрэгжүүлсэн варрант	9	2,323,974	6,320,446	(698,766)	-	-	5,621,680
Хувьцаанд суурилсан урамшуулал	9	-	-	1,572,843	-	-	1,572,843
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл, гүйлгээ		2,874,825	7,503,201	508,072	-	-	8,011,273
2024.12.31-ний байдлаар		60,356,137	\$ 165,589,487	\$ 30,656,061	\$ 2,725,582	\$ (136,753,768)	\$ 62,217,362

Дагалдах тодруулгууд нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

⁽¹⁾ Компани нь 2025 оны 9 сард энгийн хувьцааг нэгтгэсэн бөгөөд энгийн хувьцааны тоог өмнөх хугацаанд буцаан тусган тооцсон. Дэлгэрэнгүй мэдээлэлтэй Тайлбар 1-ээс танилцана уу.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан
(Канад доллар)

		12.31-нд дуусгавар болсон жилийн хугацаа	
Тодруулга		2025	2024
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Цэвэр алдагдал		\$ (8,181,842)	\$ (8,245,886)
Мөнгөн бус гүйлгээ			
Элэгдэл, хорогдол		26,183	29,828
Хувьцаанд суурилсан урамшуулал	9	1,588,308	1,572,843
Санхүүгийн орлого		(188,265)	(164,261)
Мөнгөн бус гадаад валют		1,728	(474,491)
Хараат компанийн хөрөнгө оруулалтын алдагдал	5	1,917,471	3,245,109
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын эзэмшлийн хувь бууралттай холбоотой ашиг	5	-	(1,256,598)
Мөнгөн бус эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	12	209,585	1,997,115
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		(4,626,832)	(3,296,341)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Опцион хэрэгжүүлснээс олсон орлого	9	3,374,224	816,750
Варрант хэрэгжүүлснээс олсон орлого	9	-	5,621,680
Түрээсийн өр төлбөрийн эргэн төлөлт		(13,462)	(22,939)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		3,360,762	6,415,491
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Хайгуул, үнэлгээний хөрөнгийн зардал	6	(1,498,972)	(348,887)
Үндсэн хөрөнгө, үйлдвэр тоног төхөөрөмжийн зардал		(51,533)	(27,135)
Хүүгийн орлого		188,265	164,261
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		(1,362,240)	(211,761)
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		(10,692)	41,411
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт (бууралт)		(2,639,002)	2,948,800
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эхэнд		7,298,399	4,349,599
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эцэст		\$ 4,659,397	\$ 7,298,399

Дагалдах тодруулгууд нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

1. Үйл ажиллагааны тухай:

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” “Корпораци” эсвэл “Компани” гэх) нь Канад Улсад төвтэй, үнэт болон суурь металлын хайгуулын үйл ажиллагааг Монгол Улсад эрхэлдэг. Компанийн голлох төсөл нь хараат компани болох Эрдэнэ Монгол ХХК-ийн эзэмшдэг Монгол Улсын Баянхонгор аймагт орших Баянхөндий алтны төсөл юм. Компанийн үнэт цаас нь Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр “ERD”, Монголын Хөрөнгийн Бирж дээр “ERDN” тикертэйгээр арилжаалагддаг. Компанийн албан хаяг нь 1300-1969 Upper Water Street, Halifax, Nova Scotia, B3J 2V1.

2025 оны 6 сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, тусгай хурлаар компанийн гаргасан болон эргэлтэд байгаа 6 ширхэг энгийн хувьцааг 1 ширхэг хувьцаа болгон нэгтгэх шийдвэрийг баталсан. Энэхүү нэгтгэл нь 2025 оны 9 сарын 2-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон ба компанийн гаргасан болон эргэлтэд буй 366,351,958 энгийн хувьцааны тоо ширхэг нэгтгэлийн дараа 61,063,549 ширхэг болсон. Мөн опцион болон ирээдүйд олгогдох хувьцааны нэгжүүд (deferred share units)-ийг хувьцааны нэгтгэлийн харьцаанд нийцүүлэн тохируулсан. Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөлөөс гаргасан ОУНБС (IFRS®)-ын дагуу энэхүү өөрчлөлтийг өмнөх хугацаанд буцаан тусган тооцсон бөгөөд үүний үр дүнд хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлан болон холбогдох тайлбаруудад тусгагдсан энгийн хувьцааны мэдээлэл, нэгж хувьцаанд ногдох үзүүлэлтүүд болон хувьцааны опционтой холбоотой мэдээлэл нь, өөрөөр заагаагүй бол, тайлагнасан бүх хугацаанд энэхүү нэгтгэлийг тусган харуулсан болно.

2. Тайлангийн үндэслэл

а) Мөрдсөн стандарт

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)–ын дагуу бэлтгэсэн. Нэгтгэсэн санхүүгийн тайланг ТУЗ-ийн 2026 оны 3 сарын 24-ний өдрийн шийдвэрээр гаргасан.

б) Хэмжилтийн суурь

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Тодруулга 3-т зааснаас бусдаар түүхэн өртгийн суурьд тулгуурлан бэлтгэсэн ба мөнгөн гүйлгээний мэдээллээс бусад хэсэгт аккруэл суурьт нягтлан бодох бүртгэлийн аргаар бэлтгэсэн. Эдгээр тайлбаруудад дурдсан бүх мөнгөн дүн нь, өөрөөр заагаагүй бол, Канад доллар (“\$”)–оор илэрхийлэгдэнэ. Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг Канад доллароор толилуулсан бөгөөд энэ нь Компанийн үндсэн валют болно.

в) Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцооллууд

Санхүүгийн тайланг бэлтгэх явцад СТОУС-ын шаардлагаар Компанийн удирдлага нь тайлан болон холбогдох тодруулгуудтай холбоотойгоор материаллаг өөрчлөлт, нөлөө үзүүлэх тооцоолол, таамаглалуудыг мэдээлэхийг шаарддаг. Үнэлэмж, тооцооллууд нь олон хүчин зүйлд үндэслэх бөгөөд үүнд түүхэн туршлага, одоогийн болон ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдал гэх мэт мэдээллүүдийг ашигласан. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрөх магадлалтай. Удирдлагын тооцоолол болон таамаглал, үндэслэл, төсөөлөл болон эдгээр нь нягтлан бодох бүртгэлийн стандарт, тодруулгуудад хэрхэн нөлөөлөх талаар доор танилцуулав.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлагын зүгээс гаргасан тооцоолол болон таамаглалтай холбоотой мэдээлэл нь дараах байдалтай байна:

и) *Үйл ажиллагааны тасралтгүй байдал:* Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадварыг үнэлэх нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн огнооноос хойших 12 сарын хугацаанд бий болох мөнгөн урсгалын таамаглал, мөн тухайн мөнгөн урсгалын хэрэгцээг хангах санхүүгийн боломжид тулгуурладаг. Таамаглал болон суурь нөхцөлүүдийг тогтмол дахин үнэлж, өмнөх туршлага болон бусад хүчин зүйлс, тухайлбал ирээдүйн үйл явдал, зардлын хүлээлт зэргийг харгалзан тухайн нөхцөл байдалд нийцсэн үндэслэлтэй гэж үзэн тодорхойлдог.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

2. Тайлангийн үндэслэл (үргэлжлэл)

с) Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцооллууд (үргэлжлэл)

ii) *Нөлөөллийг тодорхойлох*: Компани нь удирдан чиглүүлэх эрхийн хүрээнд өөрийн хөрөнгө оруулалт дахь хяналт, эсвэл хяналтаа хадгалаагүй тохиолдолд түүний ашиг сонирхол чухал нөлөөллийн тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг үнэлэх ба өмчийн аргаар бүртгэнэ. Удирдлага нь хууль ёсны эзэмшлийн ашиг сонирхол ба аж ахуйн нэгжүүдийн шийдвэр гаргах үйл явцын оролцоонд дүгнэлт хийх замаар дээрхийг тодорхойлдог. 2023 оны 1 сарын 10-нд (Тодруулга 5) Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК-ийн хяналтад өөрчлөлт орсноор удирдлага нь Эрдэнэ Монголд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлж, өмчийн аргаар хараат компани болгож бүртгэсэн.

iii) *Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэний бууралт*: Компани цэвэр хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрсний дараа үүссэн нэг буюу хэд хэдэн үйл явдлын үр дүнд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг үнэлэхийн тулд НББОУС 28 дагуу “Хараат аж ахуйн нэгжид ба хамтарсан үйлдвэрлэлд оруулсан хөрөнгө оруулалт”-ын удирдамжийг дагаж мөрддөг. Энэ дүгнэлтийг хийхдээ компанийн удирдлага цэвэр хөрөнгө оруулалтын үнэ цэний бууралтын бодит нотолгоо, тухайлбал: хараат компанид учирч буй санхүүгийн томоохон хүндрэл, гэрээ зөрчсөн байдал, хараат компани төлбөрийн гүйлгээ хийх чадваргүй болох эсвэл хоцрох, цаашид дампуурах эрсдэл үүсэх, санхүүгийн шинэчилсэн өөрчлөн байгуулалтад орох, эсхүл хараат компанийн санхүүгийн хүндрэлийн улмаас түүнд хөрөнгө оруулах идэвхтэй зах зээл алга болох зэрэг олон хүчин зүйлийг үнэлдэг.

iv) *Хайгуул, үнэлгээний хөрөнгийн нөхөгдөх чадвар*: Хайгуул, үнэлгээний хөрөнгүүдийг тайлант хугацаа бүрийн эцэст үнэ цэний бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор үнэлдэг. Компани нь хайгуул хийх эрх байгаа эсэх, хайгуулын зөвшөөрөл сунгагдсан эсэх, үргэлжлүүлэн хийгдэх хайгуулын ажлын зардал төсөвлөгдсөн эсэх зэргийг харгалзан холбогдох үнэлэмжийг гаргаж үнэ цэний бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлно.

Хэрэв үнэ цэний бууралтын үзүүлэлт байгаа эсвэл хайгуул, үнэлгээний хөрөнгийг техникийн хэрэгжих боломжтой, арилжааны үр ашигтай гэж тодорхойлж, улмаар үндсэн хөрөнгөд ангилах тохиолдолд нөхөгдөх үнийн тооцооллыг гаргах, энэ нь бодит үнэ цэнийг хассан устгалын зардал болон ашиглалтын үнэ цэний аль өндрөөр тооцно.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлагын зүгээс ашигласан чухал тооцоолол, таамаглалтай холбоотой мэдээллийг доор харуулав:

v) *Хувьцаанд суурилсан урамшуулал*: Ажилтнуудад олгосон хувьцаанд суурилсан урамшууллыг олгосон өдрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Бодит үнэ цэнийг Блэк Шолсийн (Black-Scholes) опцион үнэлгээний загварыг ашиглан тооцох ба ингэхдээ бодит үнэ цэнийг бүртгэх үед мэдэгдэж буй мэдээлэлд тулгуурлан хүлээгдэж буй хэлбэлзэл болон хүлээгдэж буй хугацаа гэх мэт хувьсагчуудын хүрээнд шийдвэр гаргаж үнэлэхийг шаарддаг.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд

Дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь хэрэв өөрөөр дурдаагүй бол тайлагнасан бүх хугацаанд тууштай хэрэглэгдэнэ:

а) Нэгтгэсэн тайлан бэлтгэсэн суурь

Санхүүгийн нэгтгэсэн тайланд Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци ба түүний охин компани Анианресорсиз ХХК орсон.

Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын хувьсах өгөөж ба хөрөнгө оруулалтад эзэмших эрх мэдлээрээ дамжуулан өгөөжид нөлөөлөх чадварын хүрээнд хяналтыг хэрэгжүүлдэг. Компани хяналтыг авсан өдрөөр

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

охин компанийг нэгтгэсэн санхүүгийн тайланд бүртгэх бөгөөд энэхүү хяналтыг алдсанаар нэгтгэлээс хасна. Компани хоорондын бүх гүйлгээ, үлдэгдэл, биелэгдээгүй ашиг, алдагдлыг нэгтгэх явцад хасна.

Санхүүгийн нэгдсэн тайланг гаргахдаа компани хоорондын үлдэгдэл болон гүйлгээг хасаж бүртгэсэн. Үнэ цэний бууралтын дүгнэлт байхгүй тохиолдолд бодит бус ашгийг бодит бус алдагдлын адил хасаж тооцно.

b) Гадаад валют

Компанийн үйл ажиллагааны бүртгэлийн валют нь Компани болон охин компани тус бүрийн үйл ажиллагаа явуулж буй улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг ашигладаг. Хуулийн этгээд тус бүрийн санхүүгийн тайланг бэлтгэж байхад хуулийн этгээдийн ашигладгаас өөр валютаар (гадаад валют) хийсэн гүйлгээг тухайн өдрийн ханш давамгайлж буй валютаар тооцно. Тайлангийн төгсгөл бүрд гадаад валютаар хийгдсэн бүртгэлүүд нь тухайн өдрийн валютын ханшаар дахин хөрвүүлэгдсэнээр нэгтгэсэн алдагдлын дэлгэрэнгүй тайланд валютын зөрүүний ашиг эсхүл алдагдал хэмээн бүртгэх үндэслэл болно.

Валютын ханшийн хувьд материаллаг зөрүүтэйгээс бусад үед орлого зардлын зүйлсийг функциональ валютаас тайлагнах валют руу тухайн хугацааны дундаж ханшаар хөрвүүлэн тооцно. Валютын ханш өндөр хэлбэлзэлтэй үед гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар тооцно. Үнэт цаасны гүйлгээ хийх тохиолдолд гүйлгээ хийсэн тухайн өдрийн ханшаар тооцно. Гадаад валютаар тооцогдсон хөрөнгө, өр төлбөрийн хувьд валютын зөрүү гарсан тохиолдолд бусад хуримтлагдсан хөрвүүлгийн залруулгын орлого (алдагдал)-д тооцогдоно.

Гадаад дахь үйл ажиллагааны хяналтын алдагдлын хувьд бүх ханшийн зөрүүг Компанийн эзэмшигчидтэй холбоотой үйл ажиллагааны өмчөөр хуримтлуулсан ба нэгтгэсэн алдагдлын тайланд борлуулалтын ашиг эсвэл алдагдал байдлаар бичсэн.

c) Санхүүгийн хэрэглүүр

Эрдэнэ Ресурс нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг гэрээний тал болохдоо хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн хөрөнгө, өр төлбөр нь ашиг алдагдлын бодит үнэ цэнээс бусдаар гүйлгээний зардал, анхны хүлээн зөвшөөрөлтийг нэмсэн бодит үнэ цэнээр тооцогдоно. Ашиг алдагдлын бодит үнэ цэнээр тодорхойлогдсон санхүүгийн хөрөнгө нь гүйлгээний зардал, анхны хүлээн зөвшөөрөлтийг зарлагдсан бодит үнэ цэнээр тооцогдоно.

Бодит үнэ цэнийг ангилахдаа тухайн нийт үнэ цэнийг бүрдүүлж буй доод түвшинд үндэслэн ангилдаг. Дараах хүснэгтэд Компанийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг ангилж, хэмжих нэгжээр илэрхийлэв:

Төрөл	Ангилал	Хэмжих нэгж
Мөнгө ба түүнтэй адилтгах	Санхүүгийн хөрөнгө	Элэгдэл тооцсон зардал
Авлага	Санхүүгийн хөрөнгө	Элэгдэл тооцсон зардал
Худалдаа болон бусад өглөг	Санхүүгийн өр төлбөр	Элэгдэл тооцсон зардал

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн элэгдүүлсэн өртгийг анх бодит үнэ цэнээр үнэлж, цаашид элэгдүүлсэн өртгөөр, аливаа үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэнэ.

СТОУС 9 стандартын дагуу Компани нь элэгдүүлсэн өртгөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгөнд хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварыг ашиглан алдагдлын нөөцийг хүлээн зөвшөөрдөг. Тайлант хугацаа бүрийн эцэст, хэрэв тухайн санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл анх хүлээн зөвшөөрснөөс хойш мэдэгдэхүйц өссөн бол алдагдлын нөөцийг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжээгээр тооцно. Харин тайлант хугацааны эцэст зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өсөөгүй бол алдагдлын нөөцийг 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжээгээр тооцно.

Компани нь санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээ хийх эрх дуусгавар болох эсвэл санхүүгийн хөрөнгө, түүнтэй холбоотой бүхий л эрсдэл, өгөөжийг бусад хуулийн этгээдэд шилжүүлэх үед тайлангаас хасна. Бүртгэл хийгдэхгүй болсноос үүссэн ашиг, өр төлбөрийг алдагдлын нэгдсэн тайланд тусгана.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

(с) Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

Бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах: үүнд бэлэн мөнгө, хугацаатай хадгаламж, засгийн газрын богино хугацаат үнэт цаас болон 90 хоногоос богино хугацаат мөнгөний зах зээлийн хөрөнгө оруулалт багтана.

d) Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт

Хараат компани гэж шийдвэрт нь чухал нөлөө үзүүлдэг боловч хяналт тогтоодоггүй компанийг хэлнэ. Компани нь хараат компанийн санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанд шууд оролцдоггүй. Компанийн хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын санхүүгийн үр дүнг өмчийн аргын дагуу бүртгэнэ. Өмчийн аргын дагуу хөрөнгө оруулалтыг анх бодит үнэ цэнээр нь бүртгэж, худалдан авсан өдрөөс хойш хараат компанийн ашиг, алдагдлаас Компанийн хувь эзэмшлийн хэмжээгээр дансны үнийг нэмэгдүүлж, бууруулж тусгана. Компанид ногдох хараат компанийн ашиг эсвэл алдагдлыг (орлого) алдагдлын дэлгэрэнгүй тайланд тусгасан.

Компанийн болон хараат компанийн хооронд хийгдсэн гүйлгээнээс үүссэн хэрэгжээгүй ашиг нь Компанийн хараат компанид эзэмших хувь хэмжээгээр хасагдана. Хэрэгжээгүй алдагдлыг мөн адил хасах боловч тухайн гүйлгээ нь шилжүүлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын нотолгоо болж байвал хасахгүй. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын эзэмшлийн хувь өөрчлөгдсөнөөс үүсэх хорогдуулалтын ашиг, алдагдлыг нэгтгэсэн алдагдал болон дэлгэрэнгүй алдагдлын (орлогын) тайланд тусгана.

Компани нь тайлант хугацаа бүрийн эцэст хараат компаниудад оруулсан хөрөнгө оруулалт нь үнэ цэнийн бууралтад орсон эсхийг үнэлдэг. Хэрэв үнэ цэн буурсан бол хөрөнгө оруулалтын дансны үнийг нөхөгдөх боломжит дүн хүртэл бууруулна. Нөхөгдөх боломжит дүн гэдэг нь борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэн болон ашиглалтын үнэ цэнийн аль өндөр дүнг хэлнэ. Ийнхүү тооцсон үнэ цэнийн бууралтыг нэгтгэсэн алдагдал болон дэлгэрэнгүй алдагдлын (орлогын) тайланд тусгана.

e) Хайгуул, үнэлгээний хөрөнгө

Хайгуулын зардал гэдэг нь эдийн засгийн үр ашигтай байж болзошгүй ашигт малтмалын ордыг анхлан эрэлхийлэх, эсвэл аль хэдийн нээн илрүүлсэн ордын талаар нэмэлт мэдээлэл цуглуулах зорилгоор гарсан зардлыг хэлнэ. Хайгуулын зардалд ихэвчлэн хайгуул, дээжлэлт, зураглал, өрөмдлөг болон ашигт малтмал илрүүлэхтэй холбоотой бусад ажлуудын зардал багтана.

Үнэлгээний зардал гэдэг нь хайгуулын ажлын үр дүнд тогтоогдсон эсвэл хөрөнгө оруулсан ашигт малтмалын ордыг хөгжүүлэх техникийн боломж болон эдийн засгийн ашигтай байдлыг тогтоох зорилгоор гарсан зардлыг хэлнэ.

Үнэлгээний зардалд дараах зардлууд хамаарна:

- i) өрөмдлөг, суваг малталт болон дээжлэлтээр ордын эзлэхүүн, агуулгыг тогтоох, ашигт малтмалын нөөц эсвэл батлагдсан болон магадлагдсан нөөцөд хамаарах хүдрийн биетэд хийсэн ажлууд;
- ii) олборлолтын оновчтой аргачлал болон металлургийн боловсруулалтыг тодорхойлох;
- iii) геодези, тээвэр болон дэд бүтцийн шаардлагатай холбоотой судалгаанууд;
- iv) зөвшөөрөл авахтай холбоотой үйл ажиллагаа; болон
- v) ашигт малтмалыг ашиглах нь эдийн засгийн хувьд үндэслэлтэй эсэхийг тогтоох үнэлгээнүүд, үүнд урьдчилсан үнэлгээ (scoping), урьдчилсан ТЭЗҮ (pre-feasibility), болон нарийвчилсан ТЭЗҮ (feasibility study) зэрэг багтана.

Хайгуул болон үнэлгээний зардалд тусгай зөвшөөрөл авах зардал, мөн бизнесийн нэгдлийн хүрээнд авсан хайгуул болон үнэлгээний хөрөнгийн өртөг багтана.

Компани нь NI 43-101 стандартын шаардлагад нийцсэн нөөцийг тогтоох хэмжээний хангалттай үнэлгээ хийгдсэн гэж үзэн, ТУЗ баталгаажуулалт авах хүртэл хайгуул болон үнэлгээний зардлыг гарсан үед нь зардалд бүртгэнэ. Үүнээс хойш эдгээр зардлыг хайгуул болон үнэлгээний хөрөнгө хэлбэрээр капиталжуулна. Хайгуул болон үнэлгээний хөрөнгийг олж авахтай холбоотой зардлыг мөн капиталжуулна. Энэ үе шатанд элэгдэл тооцохгүй бөгөөд холбогдох хөрөнгийг цаашид өртгөөс хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжинэ.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

е) Хайгуул, үнэлгээний хөрөнгө

Худалдан авсан эсвэл капиталжуулсан хайгуул болон үнэлгээний зардлыг тухайн төсөл техникийн хувьд хэрэгжих боломжтой, эдийн засгийн үр ашигтай болох нь нотлогдох хүртэл уг ангиллаар нь хадгална. Энэ нь ихэвчлэн бүтээн байгуулалтын зөвшөөрөлтэй давхацдаг. Техникийн хэрэгжих боломж болон эдийн засгийн үр ашигт байдал тогтоогдсоны дараа, мөн үнэ цэнийн бууралтын үнэлгээ хийсний үндсэн дээр хайгуул болон үнэлгээний хөрөнгийг тухайн хөрөнгийн шинж чанараас хамааран баригдаж буй хөрөнгө эсвэл үндсэн хөрөнгөд шилжүүлэн ангилна.

Хайгуул болон үнэлгээний хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст, эсвэл дансны үнэ нь нөхөгдөх боломжит дүнгээс давсан байж болзошгүйг илтгэх нөхцөл байдал үүссэн тохиолдолд үнэ цэнийн бууралтыг шалгана. Ийм тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнэ нь тооцоолсон нөхөгдөх боломжит дүнгээс давж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор үнэ цэнийн бууралтын тест хийнэ. Хэрэв дансны үнэ нь нөхөгдөх боломжит дүнгээс давсан бол үүссэн зөрүүг тухайн тайлант хугацаанд бүрэн хэмжээгээр үнэ цэнийн бууралтаар хүлээн зөвшөөрнө.

г) Хувьцаанд суурилсан урамшуулал

Ажилтнуудад урамшуулал болгон олгосон хувьцаанд суурилсан урамшууллыг олгосон өдрийн бодит үнэ цэнээр Блэк Шолсийн үнэлгээний загварыг ашиглан тооцно. Олгосон өдрийн бодит үнэ цэнийг эрх үүсэх хугацаанд үзүүлсэн үйлчилгээний зардалд хүлээн зөвшөөрөх бөгөөд энэ нь эцэст нь эрх үүсэхээр тооцоологдсон хувьцааны тоонд үндэслэж, зах зээлээс хамааралгүй эрх үүсэх нөхцөлийн нөлөөг тусган тохируулна.

Ажилтнуудын урамшууллаас бусад хувьцаанд суурилсан урамшууллын гүйлгээ болон ижил төстэй урамшуулал, үйлчилгээ үзүүлж буйг зах зээлийн үнийг найдвартай тооцоолж чадахгүйгээс бусад тохиолдолд хүлээн авсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн бодит үнээр хэмждэг.

н) Нэгж хувьцаанд ногдох алдагдал

Компани нь энгийн хувьцаанд ногдох суурь болон хорогдуулсан нэгж хувьцааны ашиг болон алдагдлыг тайлагнадаг. Нэгж хувьцааны суурь алдагдлыг тооцоолохдоо энгийн хувьцаа эзэмшигчидтэй холбоотой ашиг болон алдагдлыг тухайн хугацаанд зах зээлд буй нийт хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулан тооцно. Нэгж хувьцааны хорогдуулсан алдагдлыг энгийн хувьцаа эзэмшигчдийн тохируулсан ашиг болон алдагдлыг хорогдуулах боломжтой нийт энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулан, тохируулж тооцно.

Компани нь опцион, ИОХЭ болон бусад хэрэгслүүдийн хорогдуулах үр нөлөөг тооцохдоо засгийн газрын богино хугацааны хувьцааны аргыг (treasury stock method) ашигладаг. Энэхүү аргаар: нэгж хувьцааны хорогдуулсан алдагдлыг тооцоолоход ашигласан хувьцааны жигнэсэн дундаж тоо нь хувьцааны опцион хэрэгжүүлсэн, ИОХЭ, түүнтэй адилтгах хөрөнгийг ашигласнаас олсон орлогыг Компанийн энгийн хувьцааг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр буцаан худалдан авахад ашиглана хэмээн тооцоолсон. Одоо байгаа хувьцааны опцион болон ИОХЭ хүрээнд шинээр гаргах хувьцааг хорогдуулсан нэгж хувьцаанд ногдох алдагдлын тооцоонд оруулаагүй бөгөөд учир нь тэдгээрийг оруулбал хорогдуулахаас эсрэг нөлөө (anti-dilutive) үзүүлэх болно.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд

Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон стандартууд

НББОУС 21 –Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөлөл

2023 оны 8 сард НББОУС нь НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөлөлд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд энэ нь аж хуйн нэгжүүдэд валют хоорондын хөрвөх чадварыг үнэлэх, хөрвөх чадвар хангалтгүй нөхцөлд бодит ханшийг тодорхойлох аргачлалыг сайжруулахад чиглэсэн. Энэхүү өөрчлөлт нь гадаад валютаар гүйлгээ хийдэг; үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид хамаарах бөгөөд тодорхой зорилготойгоор валют хөрвүүлэх боломжгүй нөхцөлд мөн хамааралтай. Валют нь хөрвөх боломжтойд тооцогдохын тулд бусад валютыг сольж авах боломжтой (зөвшөөрөгдсөн зохицуулалтын

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд (үргэлжлэл)

Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон стандартууд (үргэлжлэл)

хүрээнд ердийн хоцрогдолтой байж болно) болон зах зээл эсвэл хөрвүүлгийн механизмын хүрээнд эрх, үүргийн дагуу солих нөхцөл бүрдсэн байх шаардлагатай. Энэхүү стандартыг мөрдөж эхэлснээр Компанид материаллаг өөрчлөлт ороогүй.

Нягтлан бодох бүртгэлд мөрдөгдөж эхлээгүй стандартууд

СТОУС 18 – Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга

2024 оны 4 сарын 9-нд НББОУСЗ (“IASB”) нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгыг орлуулах зорилгоор СТОУС 18 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга танилцуулсан. СТОУС 18 нь ашиг алдагдлын тайлангийн хүрээнд ангилал, тодорхойлсон дэд нийлбэр нэмж, удирдлагын тодорхойлсон гүйцэтгэлийн хэмжүүрүүдийн тодруулга, санхүүгийн тайлангийн мэдээллийг нэгтгэх, задлахыг сайжруулах шаардлагыг тусгасан. СТОУС 18-ын хүрээнд НББОУС 7-д нэмэлт өөрчлөлт оруулсан ба аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны орлогын дэд нийлбэрийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тайлагнах шууд бус аргаар эхлэл болгон ашиглах, мөн хүү, ногдол ашгийн төлбөрүүдийг төлсөн болон хүлээн авсан талаар тайлагнах хувилбаруудыг хасах шаардлагатай болсон. Үүнтэй адил НББОУС 33 “Нэгж хувьцаанд ногдох ашиг”-т нэмэлт өөрчлөлт оруулж, СТОУС 18-д нийт эсвэл дэд нийлбэрийн тоон үзүүлэлтээр ашиг, алдагдлын тайлангийн бусад бүрэлдэхүүн хэсгийг ашиглан нэгж хувьцаанд ногдох ашгийн нэмэлт мэдээллийг тодруулахыг зөвшөөрсөн. СТОУС 18 нь 2027 оны 1 сарын 1-ээс эхлэн тайлангийн үед хүчин төгөлдөр болох ба энэхүү хугацаанаас өмнө даган мөрдөхийг зөвшөөрсөн. Компани нь дээрх стандартыг мөрдөж эхэлснээр гарах нөлөөллийг үнэлж байна.

СТОУС 7 болон 9 - Санхүүгийн хэрэглүүр болон тодруулга

2024 оны 5 сараас эхлэн НББОУСЗ (“IASB”) Санхүүгийн хэрэглүүрийн ангилал болон үнэлгээнд (СТОУС 7 болон СТОУС 9) нэмэлт өөрчлөлт оруулсан. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдээр СТОУС 9-ийн ангилал болон үнэлгээ, СТОУС 7-ийн холбогдох тодруулгын шаардлагыг шинэчилсэн. НББОУСЗ-өөс зарим санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, данснаас хасах хугацааг тодруулж, цахим төлбөрийн системийг ашиглан санхүүгийн өр төлбөрийг барагдуулахтай холбоотой шаардлагад өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлт нь 2026 оны 1 сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр болох ба энэхүү хугацаанаас өмнө даган мөрдөхийг зөвшөөрсөн. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2026 оны 1 сарын 1-ээс ирээдүйд хэрэгжүүлэх зарчмаар хэрэглэсэн бөгөөд Компанид нөлөө үзүүлээгүй.

5. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт

2023 оны 1 сарын 10-нд Компани нь Баянхөндий алтны төслийг хөгжүүлэх зорилгоор Монголиан Майнинг Корпорэйшн (“ММС”)–тэй стратегийн түншлэл болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсныг мэдээлсэн. Стратегийн түншлэлийн үндсэн нөхцөлүүдийг доор дурдав:

- ММС нь гурван үе шаттайгаар 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Хөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК (“ЭМ”)–ын 50%-тай тэнцэх хувьцаанд хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг гаргасан.
- Эрдэнэ Ресурс нь Эрдэнэ Монгол ХХК-ийн 50%-г эзэмшихээс гадна Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эхний 400,000 унц алтны олборлолтоос давсан олборлолт болон дээрх тусгай зөвшөөрлүүдийн орчимд 5 км-ийн талбайд эзэмших тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд 5%-ийн борлуулалтын орлогын төлбөр (“Net smelter return” буюу “NSR”) (цаашид “БОТ” гэх) авах нөхцөлтэй.

2024 оны 1 сарын 23-нд хөрвөх нөхцөлтэй өрийн бичгийг хөрвүүлсэнтэй холбогдуулан Эрдэнэ Монгол ХХК нь 50%-тай тэнцэх хувьцааг нэмж гарган, ММС-г хувь эзэмшигчээр бүртгэсэн. ММС нь Эрдэнэ Монголын хувьцааг захиалсан өдөр компани нь хөрвөх нөхцөлтэй өрийн бичгээр дамжуулан ММС-ийн Эрдэнэ Монголд оруулсан хөрөнгө оруулалтаас хамааруулж тооцсон Эрдэнэ Монголд үлдсэн \$1,256,598 долларын хөрөнгө оруулалтыг бууруулсны ашгийг хүлээн зөвшөөрсөн. 2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд компанийн хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн хураангуйг доор харуулав.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт, 2025.01.01	\$	53,109,742
Хараат компаниас хүлээсэн алдагдал, 2025.12.31		(1,917,471)
Гадаад валютын өөрчлөлтийн нөлөөлөл		(4,266,906)
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт, 2025.12.31		46,925,365

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт, 2024.01.01		51,248,731
Хараат компаниас орсон орлого, 2024.01.23-ны байдлаар		54,073
Хорогдуулалтын орлого, 2024.01.23-ны байдлаар		1,256,598
Хараат компаниас хүлээсэн алдагдал, 2024.01.23		(3,299,182)
Гадаад валютын өөрчлөлтийн нөлөөлөл		3,849,522
2024.12.31-ны байдлаар хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	\$	53,109,742

Дараах хүснэгтүүдэд өмчийн аргаар бүртгэх зорилгоор Компанийн хийсэн бодит үнэ цэнийн тохируулгуудыг харгалзан, ЭМ-ийн нэгтгэсэн санхүүгийн мэдээллийг 100 хувийн үндсэн дээр хураангуйлан үзүүлэв. ЭМ-ийн хураангуй санхүүгийн мэдээллийг Компанийн хөрөнгө оруулалтын дансны үнэтэй тулган баталгаажуулсан тооцоолол нь дараах байдалтай байна:

Хугацаанд	12 сарын 31 2025	12 сарын 31 2024
Нийт эргэлтийн хөрөнгө	\$ 41,517,739	\$ 26,826,631
Нийт эргэлтийн бус хөрөнгө	252,129,590	190,020,662
Нийт богино хугацааны өр төлбөр	(90,948,567)	(6,993,430)
Нийт урт хугацааны өр төлбөр	(108,848,032)	(103,634,379)
Нийт хөрөнгө	\$ 93,850,730	\$ 106,219,484

12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд	2025	2024
Орлого	\$ 43,260,771	\$ -
Алдагдал	3,834,942	6,541,648

Хугацаанд	12 сарын 31 2025	12 сарын 31 2024
Эрдэнэ Монголын нийт хөрөнгө	\$93,850,730	\$106,219,484
Эрдэнэ Ресурсийн хувь хэмжээ	50.00%	50.00%
Эрдэнэ Ресурс-д ногдох нийт хөрөнгө	46,925,365	53,109,742
Эрдэнэ Монгол дахь хөрөнгө оруулалтын үлдэх өртөг	46,925,365	53,109,742

6. Хайгуул, үнэлгээний хөрөнгө

Компанийн хайгуул болон үнэлгээний хөрөнгөд Монгол Улсад орших Зуун Мод болон Тэрэг Уул талбай багтдаг.

Зуун Мод төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт 6,041 га талбайг хамардаг бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайд молибден-зэсийн нөөц бүхий орд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд олгосон. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгодог ба 20 жилээр 2 удаа сунгах боломжтой. 2007 оны 7 сарын 1-ний байдлаар Компани нь хангалттай үнэлгээ хийгдсэн гэж үзэн уг төслийн зардлыг капиталжуулж эхэлсэн. Иймд 2007 оны 7 сарын 1-ээс эхлэн энэхүү тайлангийн огноо хүртэл Зуун Мод төсөлтэй холбоотой бүх хайгуул болон үнэлгээний зардлыг капиталжуулж байна.

2025 оны 7 сарын 2-ны өдөр Компани нь Монгол Улсын Өмнөговь аймагт, Оюу Толгой ордоос баруун өмнө зүгт ойролцоогоор 10 км зайд байрлах Тэрэг Уул зэс-алтны порфирийн хэтийн төлөв бүхий талбайд 80 хүртэлх хувийг олж авах опцион гэрээг байгуулсан. Гэрээний нөхцөлийн дагуу Эрдэнэ Ресурс нь 12 сарын хугацаанд 300,000 ам.долларыг хайгуулын зардалд зарцуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигч ("option grantor")-д 200,000 ам.долларын төлбөр төлөх үүрэг хүлээнэ. Тус гэрээний нэг, хоёр болон гурав дахь жилийн ойд Компани нь 400,000; 500,000 болон 900,000 ам.долларын төлбөрийг төлөх нөхцөлтэй бөгөөд хайгуулын үйл ажиллагаанд 3,000,000 ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

6. Хайгуул, үнэлгээний хөрөнгө (үргэлжлэл)

Компани нь гэрээ зурагдсанаас хойш гурав болон дөрөв дэх жилийн хооронд тусгай зөвшөөрөл эзэмшигчид 3 сая ам.долларын төлбөрийг төлснөөр Тэрэг Уул Майнс ХХК-ийн 51%-ийг эзэмших эрхтэй болно. Эрдэнэ Ресурс нь нийт 10 сая ам.долларын хайгуул болон үнэлгээний зардал гаргаж, мөн нэмэлтээр 3 сая ам.долларын төлбөрийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлснөөр гэрээний найм дахь жилийн ойгоос өмнө 80 хүртэлх хувийн эзэмшлийг авах боломжтой. Дээрх төлбөрийг компанийн саналаар бэлэн мөнгө эсвэл хувьцаагаар төлөх боломжтой. Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд Эрдэнэ Ресурс нь бүх хайгуулын үйл ажиллагааг удирдан гүйцэтгэх бөгөөд аль ч хугацаанд торгуульгүйгээр гэрээг цуцлах эрхтэй.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн хугацаанд Компани нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлсөн 300,448 долларын худалдан авалтын төлбөрийг хайгуул болон үнэлгээний хөрөнгөд капиталжуулсан. 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Компани нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу зардлыг капиталжуулж эхлэхэд шаардлагатай хангалттай үнэлгээг хараахан гүйцэтгээгүй тул 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн хугацаанд Тэрэг Уул төсөлтэй холбоотой 303,884 долларын хайгуул болон үнэлгээний зардлыг зардалд бүртгэсэн (2024 онд: 0 ам.доллар).

2024, 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд Компанийн хайгуул, үнэлгээний хөрөнгийн өөрчлөлтийн хураангуйг доор харуулав:

	2025.12.31	2024.12.31
1 сарын 1-ний байдлаар	2,468,070	1,961,506
Нэмэгдэл	1,498,972	348,887
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(185,358)	157,677
	3,781,684	2,468,070

7. Гэрээгээр хүлээсэн үүрэг

Компани батлан дааж, Эрдэнэ Монголын эзэмшиж буй Алтан нар, Хөндий, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр ("NSR")-ийг Роял Гоулд Инк. (Royal Gold Inc)-д төлөх үүрэг хүлээсэн. Роял Гоулд Инк. нь дээрх тусгай зөвшөөрлийн хувьд ирээдүйн роялти ба стрийм санхүүжилттэй холбоотой татгалзах эрх эдлэх нөхцөлтэй.

Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд 1.5%-ийн NSR төлбөрийг Версамет Роялтис (Versamet Royalties Corp.)-д төлөх үүрэгтэй. Энэхүү гэрээний хүрээнд Компани нь Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд олборлолтын тодорхой шатанд хүрснээр тодорхой хувийг эргэн худалдан авах эрх үүснэ.

Баянхөндий алтны төслийг хөгжүүлэх зорилгоор 2024 оны 2 сарын 8-ны өдөр Эрдэнэ Ресурс нь MMC-тэй төслийн санхүүжилтийн гэрээг байгуулав. Эрдэнэ Ресурс болон MMC нар нь Эрдэнэ Монгол ХХК-ийг хамтран эзэмшдэг ба тус санхүүжилт нь MMC-ээс хувь эзэмшигчийн зээлийн нөхцөлөөр олгогдоно. Зээлийн хүрээнд Эрдэнэ Ресурс нь Эрдэнэ Монгол ХХК дахь өөрийн эзэмшлийн 50% болон Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эзэмших борлуулалтын орлогын төлбөр ("Net smelter return" буюу "NSR") (цаашид "БОТ" гэх)-ийг барьцаа хөрөнгө болгоно. Зээлийн эргэн төлөгдөх хугацаанд талуудын хооронд байгуулсан Стратегийн түншлэлийн гэрээний дагуу MMC давуу эрхийн саналтай байх бөгөөд Эрдэнэ Ресурсийн Зуун Мод төслийн хувьд тэргүүн ээлжид татгалзах эрх эдэлнэ. Эрдэнэ Ресурс нь MMC-тэй адил нөхцөлөөр зээлийн 50%-ийг хувьцаа эзэмшигчийн зээл хэлбэрээр олгох боломжтой.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

8. Орлогын татвар

Компанийн орлогын албан татварын сан нь тооцоолсон дүнгээс ялгаатай байгаа нь Канадын Улсын болон мужийн татварын хувийг нэгтгэсэн дүнг орлогын албан татварын өмнөх цэвэр алдагдалд ашигласан бөгөөд доор харуулав:

	12 сарын 31 2025	12 сарын 31 2024
Албан татварын хувь хэмжээ	29.0%	29.0%
Албан татварын хувь хэмжээгээр тооцсон орлогын албан татвар (нөхөгдөх)	\$ (2,373,000)	\$ (2,391,000)
Түр хугацааны тооцогдоогүй зөрүүгийн ашиг	1,447,000	1,155,000
Татварын зориулалтаар хасагдахгүй зардлууд	487,000	525,000
Гадаад улсын татварын хувь хэмжээний нөлөө	161,000	134,000
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын тооцогдоогүй алдагдал	278,000	941,000
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын хувь хэмжээ буурснаас үүссэн ашгаас үүсэх зөрүү	-	(364,000)
Орлогын албан татварын ногдуулах	\$ -	\$ -

Компанийн орлогын албан татварын тооцоололд Канад Улсад мөрдөгдөж буй 29.0% (2024 – 29.0%) болон Монгол Улсад мөрдөгдөж буй 10.0% (2024 – 10.0%) татварын хувь хэмжээг ашигласан.

Доорх хүснэгтэд компанийн хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө (өр төлбөр)-ийг харуулав:

	12 сарын 31 2025	12 сарын 31 2024
Урагшлуулсан хөрөнгийн бус алдагдал	-	\$ 407,000
Түрээсийн өр төлбөр	\$ 25,000	-
Хойшлуулсан орлогын татварын хөрөнгө	25,000	407,000
Бодит бус гадаад валютын ханшийн зөрүү	(25,000)	(407,000)
Хойшлуулсан цэвэр орлогын албан татварын хөрөнгө (өр төлбөр)	\$ -	\$ -

Доорх хүснэгт дэх түр хугацааны зөрүү, хөрөнгийн бус алдагдал болон хөрөнгийн алдагдлыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгаагүй.

	2025.12.31		
	Канад Улс	Монгол Улс	Нийт
Урагшлуулсан хөрөнгийн бус алдагдал	\$ 31,516,000	\$ 919,000	\$ 32,435,000
Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж	282,000	-	282,000
Үнэт цаас гаргахтай холбоотой зардлууд	83,000	-	83,000
Биет бус хөрөнгө	378,000	-	378,000
Хайгуул, үнэлгээний хөрөнгө	26,000	4,009,000	4,035,000
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	15,808,000	-	15,808,000
	\$ 48,093,000	\$ 4,928,000	\$ 53,021,000
	2024.12.31		
	Канад Улс	Монгол Улс	Нийт
Урагшлуулсан хөрөнгийн бус алдагдал	\$ 27,507,000	\$ 148,000	\$ 27,655,000
Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж	274,000	-	274,000
Үнэт цаас гаргахтай холбоотой зардлууд	281,000	-	281,000
Биет бус хөрөнгө	378,000	-	378,000
Хайгуул, үнэлгээний хөрөнгө	-	4,361,000	4,361,000
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	4,069,000	-	4,069,000
	\$ 32,509,000	\$ 4,509,000	\$ 37,018,000

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

2025 оны 12 сарын 31-ний байдлаар компани нь ирээдүйн татвар ногдох орлогод суутган тооцох боломжтой хөрөнгийн бус алдагдалтай байна. Дээрх хөрөнгийн бус алдагдлын хүчинтэй хугацааг доорх хүснэгтэд харуулав:

	12 сарын 31 2025	12 сарын 31 2024
2025	-	6,000
2026	1,509,000	1,509,000
2027	2,319,000	2,319,000
2028	1,016,000	-
Түүнээс цааш	27,585,000	25,225,000
	\$ 32,429,000	\$ 29,059,000

9. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө

2025 оны 9 сарын 2-нд Компани нь гаргасан болон эргэлтэд буй хувьцааг 6:1 харьцаатай нэгтгэсэн. Ингэснээр 6 ширхэг энгийн хувьцааг нэгтгэн, нэгтгэлийн дараа 1 ширхэг энгийн хувьцаа болсон. Энгийн хувьцаа, нэгж хувьцаанд ногдох үзүүлэлт болон хувьцааны опцион, ИОХЭ-тэй холбоотой бүх мэдээлэл нь тайлагнасан бүх хугацаанд энэхүү хувьцааны нэгтгэлийг тусган харуулсан болно.

Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй.

Варрант

2025 оны 12 сарын 31-ний байдлаар хэрэгжүүлэх боломжтой варрант байхгүй ба 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд варрант хэрэгжээгүй. 2024 оны 12 сарын 31-ний байдлаар 2,323,974 варрантыг хэрэгжүүлж, \$5,621,680 долларын орлого төвлөрүүлсэн ба 1,886,733 варрантын хугацаа дууссан.

Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр болон Залгамж халааны төлөвлөгөө

2023 оны 6 сарын 22-ны өдөр Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр” (“ХСУБХ” буюу “Omnibus plan”) баталсан. ХСУБХ нь опцион (“Опцион” буюу “Options”), хязгаарлалт бүхий хувьцааны нэгж (“ХБХН” буюу “RSUs”) гүйцэтгэлд суурилсан хувьцааны нэгж (“ГСХН” буюу “PSUs”) ирээдүйд олгогдох хувьцааны эрх (“ИОХЭ” буюу “DSUs”) зэрэг хувьцаанд суурилсан урамшууллыг харьцангуй уян хатан байдлаар компани болон охин компаниудын захирал зөвлөхүүд, ажилтнуудад олгон, урт хугацаанд тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлнэ. ХСУБХ нь батлагдсанаар Залгамж халааны төлөвлөгөө болох хувьцаанд суурилсан опционы төлөвлөгөө, ИОХЭ-ийн төлөвлөгөөг орлоно. Тус төлөвлөгөөнүүдийн дагуу олгогдсон урамшуулал нь хүчин төгөлдөр хугацаа дуусгавар болтол хүчинтэй.

ХСУБХ нь хувьсах төлөвлөгөө бөгөөд тус хөтөлбөрийн дагуу олгосон энгийн хувьцааны тоо хэмжээ нь (Залгамж халааны төлөвлөгөөгөөр олгосон урамшууллыг багтаасан) Компанийн гаргасан болон арилжиж буй энгийн хувьцааны нийт хэмжээний 10%-аас хэтрэхгүй байх ёстой.

Хувьцааны опцион

Компани нь хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр болон залгамж халааны төлөвлөгөөний дагуу Компанийн ТУЗ-ийн гишүүд, удирдлага, ажилтан албан тушаалтнуудад компанийн хувьцааг худалдан авах боломж бүхий опционыг олгодог. Опционыг хэрэгжүүлэх, олгох нөхцөлүүдийг ТУЗ тодорхойлно. Опцион олгогдох үед нөхцөлийг өөрөөр заагаагүй бол олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2024, 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон нэг жилийн хугацаанд үнэт цаасны опционд гарсан өөрчлөлтүүд:

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

	2025.12.31		2024.12.31	
	Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж		Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж	
	Опционы тоо	үнэ	Опционы тоо	үнэ
1 сарын 1-ний байдлаар	3,740,896	\$ 2.10	3,414,243	\$ 2.10
Олгосон	612,518	1.88	946,674	1.80
Хугацаа дууссан	-	-	(69,170)	2.40
Хэрэгжүүлсэн	(1,378,175)	2.45	(550,851)	1.48
12 сарын 31-ний байдлаар	2,975,239	\$ 2.43	3,740,896	\$ 2.10
12 сарын 31-ний байдлаар хэрэгжүүлэх боломжтой	2,975,239	\$ 2.43	3,740,896	\$ 2.10

2024 болон 2025 онд олгосон бүх опцион нь таван жилийн хугацаанд, шууд хэрэгжүүлэх боломжтой опцион юм. Доорх хүснэгтэд 2024, 2025 оны 12 сарын 31-ний байдлаар хэрэгжүүлэх боломжтой бүх гаргасан опционы мэдээллийг харуулав.

Дуусах хугацаа	2025.12.31		2024.12.31	
	Опционы тоо	Хэрэгжүүлэх үнэ	Опционы тоо	Хэрэгжүүлэх үнэ
2025-02-11	-	-	8,334	1.62
2025-05-13	-	-	83,335	1.32
2025-08-27	-	-	510,010	2.94
2025-12-01	-	-	33,334	2.28
2026-06-23	246,671	2.22	512,512	2.22
2026-08-18	33,334	2.58	33,334	2.58
2026-10-28	-	-	16,667	2.58
2027-08-09	432,709	1.86	632,516	1.86
2027-12-30	29,167	1.80	29,167	1.80
2028-05-09	839,173	2.16	968,347	2.16
2029-02-12	841,672	1.80	913,340	1.80
2030-02-03	402,507	3.60	-	-
2030-06-25	100,006	5.46	-	-
2030-09-24	50,000	8.19	-	-
	2,975,239	\$ 2.43	3,740,896	\$ 2.10

2024 болон 2025 оны 12 сарын 31-ний хугацаанд гаргасан опционы үнэ цэнийг опцион гаргах үед Блэк Шолсийн опционы үнэлгээний загварыг ашиглан, жигнэсэн дундаж үнээр тогтоосон:

	2025.12.31		2024.12.31	
Гаргах өдрийн хувьцааны үнэ	\$	4.32	\$	1.95
Хэрэгжүүлэх үнэ	\$	4.35	\$	1.80
Эрсдэлгүй хүүгийн түвшин		2.6%		3.8%
Хүлээгдсэн хугацаа		4.3 жил		4.6 жил
Хүлээгдсэн хэлбэлзэл		53%		54%
Хүлээгдсэн ногдол ашиг		0.0%		0.0%
Гаргах өдрийн зах зээлийн жигнэсэн дундаж үнэ	\$	1.88	\$	0.99

Хүлээгдсэн хэлбэлзлийг үнэт цаасны түүхэн ханшийн хэлбэлзлийг харгалзан тооцсон.

2025 онд гаргасан опционтой холбоотойгоор \$1,152,275 долларын зардлыг хувьцаанд суурилсан урамшууллын зардалд хүлээн зөвшөөрч, хайгуул болон үнэлгээний зардал болон захиргааны зардалд тус тус багтаасан. (2024 – \$939,500)

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

Ирээдүйд олгогдох хувьцааны эрх ("DSU")

2025 оны 12 сарын 31-ний байдлаар Компани нь таван өдрийн дундаж жигнэсэн дундаж ханшаар үнэлсэн буюу нэгж тус бүр нь \$5.22 долларын бодит үнэ цэн бүхий 83,543 ширхэг ирээдүйд олгогдох хувьцааны эрх олгосон (2024 – \$2.45 үнэлсэн 258,165 ширхэг ИОХЭ олгосон). Бодит үнэ цэн нь \$436,033 (2024 – \$633,343) бүхий ИОХЭ нь Захиргаа, удирдлагын зардал болон хайгуул, үнэлгээний зардалд тусгагдсан. Эрдэнэ Ресурс нь тухайн онд ИОХЭ-тэй холбоотойгоор нэгж тус бүр нь \$1.61 долларын үнэ цэн бүхий 135,015 энгийн хувьцаа гаргасан. (2024 онд гаргаагүй).

Олгосон өдрөөс ирээдүйд олгогдох хувьцааны эрхийг шууд хэрэгжүүлэх боломжтой. Хугацаа дуусгавар болох, эсвэл хөтөлбөрт хамрагдсан гишүүн нас барсан тохиолдолд Компани тухайн гишүүний хувийг бэлэн мөнгөөр эсвэл үнэт цаасаар зах зээлийн үнэлгээгээр худалдан авах боломжтой. Энэ нь Компанийн сонголтоор хийгдэх бөгөөд Компани бэлэн мөнгөөр худалдан авахгүйгээр шийдвэрлэвэл энэхүү төлөвлөгөө нь үнэт цаасанд суурилсан хөтөлбөрт шилжинэ. 2023 оны 6 сарын 22-нд батлагдсан хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийн төлөвлөгөө дэх ИОХЭ-ийн нөхцөлүүд нь хуучин хэрэгжиж байсан ИОХЭ-ийн хөтөлбөрийн заалтуудтай нийцэж байна.

2024, 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн байдлаар ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн тухай мэдээлэл:

	2025.12.31	2024.12.31
	Тоо ширхэг	Тоо ширхэг
1 сарын 1-ний байдлаар	1,665,223	1,407,058
Олгосон	83,543	258,165
Гаргасан	(135,015)	-
12 сарын 31-ний байдлаар	1,613,751	1,665,223

10. Хайгуул болон үнэлгээний зардал

2024, 2025 оны 12 сарын 31-ний байдлаар хайгуул болон үнэлгээний зардлын мэдээллийг доор хүснэгтэд харуулав:

	12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд	
	2025	2024
Элэгдэл хорогдол	\$ 5,622	\$ 4,227
Шууд зардал	846,996	383,557
Ажилтан, албан тушаалтнуудын урамшуулал	2,223,645	2,046,890
Хувьцаанд суурилсан урамшуулал	571,500	518,129
Хараат компаниас нөхөн төлсөн	(1,199,531)	(1,100,161)
	\$ 2,448,232	\$ 1,852,642

Компани болон хараат компани нь геологийн үйлчилгээ үзүүлсний хүрээнд суутгах татварыг хасаж тооцсон жилд нэг сая ам.долларыг нөхөн төлөх гэрээтэй.

11. Ерөнхий, захиргааны зардал

2024, 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд ерөнхий, захиргааны зардлын мэдээллийг дор харуулав:

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

	12 сарын 31-д дуусгавар болсон жил	
	2025	2024
Захиргааны үйлчилгээ	\$ 1,332,226	\$ 1,198,872
Санхүүжилтийн зардал	-	1,495,147
Хөрөнгө оруулагчтай харилцах, маркетинг	472,714	487,533
Оффис ба бусад	147,057	122,465
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	499,460	379,827
Зохицуулагч байгууллагын төлбөр, зардлууд	379,843	205,650
Хувьцаанд суурилсан урамшуулал	1,016,808	1,054,714
Томилолтын зардал	149,852	98,850
	\$ 3,997,960	\$ 5,043,058

12. Мөнгөн гүйлгээний нэмэлт мэдээлэл

	12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд	
	2025	2024
Үйл ажиллагааны эргэлтийн хөрөнгийн мөнгөн бус өөрчлөлт		
Авлага	\$ (304,518)	\$ (8,188)
Урьдчилж төлсөн зардал	(145,991)	1,385,664
Худалдаа болон бусад өглөг	660,094	619,639
	\$ 209,585	\$ 1,997,115

13. Санхүүгийн хэрэглүүр

Зээлийн эрсдэл:

Зээлийн эрсдэл нь санхүүгийн хөрөнгийн хамгийн өндөр эрсдэлийг агуулдаг. Тайлангийн өдрөөр тасалбар болгон зээлийн эрсдэл хамгийн их хүлээж буй хөрөнгийг харуулбал:

	Дансны дүн	
	12 сарын 31 2025	12 сарын 31 2024
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах	\$ 4,659,397	\$ 7,298,399
Авлага	319,428	14,910
	\$ 4,978,825	\$ 7,313,309

Компани нь өөрийн бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн дийлэнх хэсгийг Канадын санхүүгийн байгууллагуудад байршуулж зээлийн эрсдэлийг удирддаг бөгөөд удирдлагын зүгээс алдагдал хүлээх эрсдэл бага гэж үздэг. 2025 оны 12 сарын 31-ний байдлаар \$159,413 доллар буюу бэлэн мөнгөний 3% нь Канадаас бусад банкнуудад хадгалагдаж байсан (2024 - \$121,756 доллар буюу 2%).

Төлбөрийн чадварын эрсдэл:

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. Компани нь энэхүү эрсдэлийн удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг. Компанийн бүх санхүүгийн өр төлбөрийг ирэх арван хоёр сарын дотор барагдуулахаар төлөвлөж байна.

Зах зээлийн эрсдэл:

Зах зээлийн эрсдэл нь үнэт цаасны ханш, таваарын зах зээл, валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай эрсдэлүүдийг хэлнэ.

а) Хүүгийн эрсдэл

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

Компани нь илүүдэл бэлэн мөнгийг хүүтэй хадгаламжийн дансанд байршуулж байгаа нь хүүгийн эрсдэл үүсгэх магадлалтай.

б) Гадаад валютын эрсдэл

Компанийн үйл ажиллагааны голлох валют нь канад доллар бөгөөд охин, хараат компанийн голлох валют нь монгол төгрөг юм. Түүнээс гадна, Компани нь америк доллароор зардал гаргадаг. Иймээс канад долларын бусад валюттай харьцах хэлбэлзэл нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Валютын хөрвөх эрсдэл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдэд ам.доллароор илэрхийлэгдэх бэлэн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, худалдаа болон бусад өглөг багтаж байна.

Компанийн гадаад валют (ам.доллар)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

	12 сарын 31 2025	12 сарын 31 2024
Мөнгө ба түүнтэй адилтгах	\$ 195,319	\$ 414,149
Авлага	297,108	-
Худалдаа, бусад өглөг	(33,289)	(12,461)
	\$ 459,138	\$ 401,688

Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$45,900 долларын цэвэр алдагдал (ашиг) дагуулах магадлалтай (2024.12.31 - \$40,200).

Компанийн гадаад валют (монгол төгрөг)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

	12 сарын 31 2025	12 сарын 31 2024
Мөнгө ба түүнтэй адилтгах	\$ 21,974	\$ 12,341
Авлага	17,588	15,043
Худалдаа, бусад өглөг	(15,832)	(1,991)
	\$ 23,730	\$ 25,393

Монгол төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$2,400 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (2024.12.31 - \$2,500).

с) Үнийн эрсдэл

Компанийн санхүүгийн хэрэгслүүд нь эрдсийн хайгуул, олборлолтын салбарын таваарын үнийн хэлбэлзлээс бусад байдлаар үнийн шууд эрсдэлд орох магадлал багатай.

Бодит үнэ цэн:

Нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл санхүүгийн тайлангийн тодруулгад тусгагдсан бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө ба өр төлбөрийг бодит үнэлгээний шатлалын дагуу ангилдаг бөгөөд энэхүү шатлал нь бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан өгөгдлийн ач холбогдлыг илэрхийлнэ. Үүнд:

- а) Түвшин 1: Идэвхтэй зах зээл дэх ижил хөрөнгө эсвэл өр төлбөрийн үнийн санал (тохируулаагүй)
- б) Түвшин 2: Түвшин 1-д багтсан үнийн саналаас бусад өгөгдөл, үүнд шууд (жишээ нь үнэлгээ), эсвэл шууд бус (үнэлгээнээс үүдэлтэй) хөрөнгө эсвэл өр төлбөр багтсан
- с) Түвшин 3: Зах зээлийн өгөгдлөөр ажиглах боломжгүй хөрөнгө эсвэл өр төлбөрийн өгөгдлүүд

Компанийн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн нь дансны үнэтэй ойролцоо гэж үздэг.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллар, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад)

2024 болон 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

14. Холбогдох талууд

Компанийн голлох удирдах ажилтнуудад ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх албан тушаалтнууд багтдаг. Эдгээр голлох удирдлагын ажилтнуудын цалин урамшууллыг доор харуулав:

	12 сарын 31	
	2024	2024
ТУЗ-ийн гишүүдийн цалин	\$ 126,200	\$ 111,000
Хувьцаанд суурилсан урамшуулал	534,450	645,600
Ажилтнуудын цалин, урамшуулал	1,860,966	1,677,280
Голлох албан тушаалтнуудын хувьцаанд суурилсан урамшуулал	427,250	587,337
	\$ 2,948,866	\$ 3,021,217

15. Тайлант хугацаанаас хойш өрнөсөн үйл явдлууд

2026 оны 2 сарын 5-ны өдөр Компани нь хаалттай, тогтоосон үнээр худалдан авах баталгаа гаргасан (bought deal) санхүүжилтийн хүрээнд 3,230,000 ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг 8.90 ам.долларын үнээр гарган, нийт 28,747,000 ам.долларын санхүүжилт татан төвлөрүүлснээ зарласан. Энэхүү хаалттай санхүүжилтийн хүрээнд Paradigm Capital Inc. болон National Bank Financial Inc. компаниуд тэргүүлэх андеррайтераар, BMO Capital Markets оролцон ажилласан.

Орчуулга: Энэхүү тайлан нь англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.